



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 265

Улаанбаатар хот

“Эм Ай Би Жи” ХХК-д гадаад улсын  
үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад  
зуучлах үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.16, Хорооны 2014 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам”-ын 9<sup>1</sup> дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эм Ай Би Жи” ХХК-д гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Эм Ай Би Жи” ХХК /А.Билгүүн/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000275